


1. Баруун хойд зүгийг зааж буй луужинг сонгоорой.




A.

B.

C.

D.

2. Зураг дахь хэд дугаартай байрлалд хойд өргөргийн улс орнуудад зуны улирал тохиох вэ?



A. 1

B. 2

C. 3

D. 4

3. Хоёр тивээс бүрдсэн эх газрыг сонгоорой.

A. Австрали

B. Еврази

C. Америк

D. Антарктид

4. Дэлхийн гадаад хүчний нөлөөг хэд дугаартай зураг илэрхийлэх вэ?



A. 1

B. 2

C. 3

D. 4

5. Нарны гэрлийн тусгалын өнцөг хэдэн градусаар тусахад хамгийн дулаан байх вэ?

A. 55°

B. 90°

C. 65°

D. 27°

6. Усны хатуу төлөвт орших төрлийг сонгоорой.


A. гол мөрөн

B. нуур цөөрөм


C. мөнх цас

D. булаг шанд

7. Дэлхийн далайн эргэн тойронд үүсэх хойг болон булангийн ялгааг илэрхийлсэн зургийг сонгоорой.




Тропикийн өвслөг газар нутаг буюу саванны бүс дэх ойн тархалтын зургийг ажиглан асуултад хариулаарай.



8. Аль тивийн саванны тархалтыг голлон харуулсан байна вэ?
- A. Өмнөд Америк B. Австрали
C. Антарктид D. Африк
9. Саванны зургийг ажиглан онцлог шинжийг тодорхойлсон хувилбарыг сонгоорой.
- A. намхан, тачир ургах бөгөөд кактус мэт өргөстэй мододтой.
B. хүйтэн, сэрүүнд дасан зохицох чадвартай өндөр мододтой.
C. өвс ургамал нь ихэнхдээ өндөр ургах ба өргөн навчит мододтой.
D. ихэнхдээ ургамлын үндэс нь урт ургах хэдий ч навчгүй мододтой.

10. Сахарын цөлийн уур амьсгалын диаграммыг зургаар илэрхийлэв. Ямар улиралд тунадас хамгийн бага унасан байна вэ?



A. зун

B. өвөл

C. хавар

D. намар

11. Сахарын цөл дэх тунадасны хэмжээ хамгийн их болон, хамгийн бага үеийг тодорхойлон дунджийг тооцоолж олоорой.

A. 6 мм


B. 5 мм

C. 4 мм

D. 3 мм

12. Шинэ Зеландын газарзүйн зургийг ажиглан хамгийн ХОЙД захын цэгийн солбицлыг тодорхойлсон хувилбарыг сонгоорой.

ШИНЭ ЗЕЛАНД



A. ӨӨ36°, ЗУ174°

B. ӨӨ38°, ЗУ179°

C. ӨӨ35°, ЗУ175°

D. ӨӨ34°, ЗУ173°


13. Монгол улсын нийслэл Улаанбаатар хот нь $3У106^0$, $ХӨ47^0$ -ын солбицолд оршдог бол 3 цагаар хоцрох улсын байрлалыг тооцоолж олоорой.

(Дэлхийг 24 цагийн бүсэд хуваах ба 1 цагт 15^0 -ын нутаг багтдаг.)

- A. $3У151^0$ B. $3У92^0$ C. $3У61^0$ D. $3У45^0$


14. Хэсэг уулчид авиралт хийхээр зураг дахь уулын оргилд гарахаар тохиролцсон байна. Уулчид хэдэн метрийн өндөрт гарах вэ?

Газрын гадаргад нарны гэрэл тусаж халснаар агаар дээш хөөрөх тусам нягт нь багасаж, агаарын урсгалтай нийлснээр температур нь буурах буюу 100 метр өгсөх тутам 0.6^0C -аар буурдаг зүй тогтолтой.



- A. 1830 метр
B. 4000 метр
C. 5830 метр
D. 7667 метр

Ганга мөрний тухай зураг болон мэдээллийг ашиглан даалгавруудыг гүйцэтгээрэй.



Ганга мөрөн нь Гималайн нурууны баруун өврөөс эх авч Энэтхэг, Бангладешийн нутгаар дамжин 2525км урсаад Бенгалын буланд цутгадаг. Мөн Энэтхэгийг хүрээлсэн далайн дулаан урсгалууд байдаг учир усны түвшин өндөр байдаг. Ганга мөрөн нь эртнээс олон хүнийг тэжээсэн үржил шимт газар бөгөөд одоо Ганга мөрний сав газарт 400 сая хүн (Энэтхэгийн хүн амын 30 хувь) сууж нэг км²-д 390-үүлээ чихэлдэж байна.

15. Энэтхэгийг хүрээлсэн далайн дулаан урсгалуудын хамгийн гол нөлөөг зөв илэрхийлсэн хариуг сонгоорой.

- A. Чийглэг дулаан уур амьсгал бүрдсэн. B. Газар нутгуудад бүгдэд нь цөл үүссэн.
C. Шим тэжээлтэй хөрс бүрдсэн. D. Өндөрлөг газрын гадарга бүрдсэн.

16. Ганга мөрнийг зөв тодорхойлсон хувилбарыг сонгоорой.

- A. Ази тивийн газар нутагт хамаарах бөгөөд Энэтхэгийн далайн ай савд цутгана.
B. Африк тивийн газар нутагт хамаарах бөгөөд Бенгалын булангийн ай савд цутгана.
C. Африк тивийн газар нутагт хамаарах бөгөөд Энэтхэгийн далайн ай савд цутгана.
D. Ази тивийн газар нутагт хамаарах бөгөөд Бенгалын булангийн ай савд цутгана.

17. Ганга мөрний эргийн дагуу амьдарч буй хүмүүсийн үйл ажиллагаануудыг эерэг болон сөрөг байдлаар ялгасан хувилбарыг сонгоорой. (Эерэг – Э, Сөрөг – С үсгээр тэмдэглэсэн)

№	Үйл ажиллагаа	Эерэг	Сөрөг
1	Загас агнуур нь хүмүүсийн амьжиргааг дэмждэг.		
2	Хүн амын нягтшил ихсэж хог хаягдал нэмэгддэг.		
3	Эргийн дагуу аялал жуулчлалаа хөгжүүлдэг.		
4	Үйлдвэрийн бохир уснаас болж загас хорогддог.		

A. 1-Э,2-Э,3-С,4-С B. 1-Э,2-С,3-Э,4-Э C. 1-Э,2-С,3-Э,4-С D. 1-С,2-Э,3-Э,4-С


18. Аль туршилт нь уг галт уулын үйл ажиллагааг хамгийн ойр загварчилж чадах вэ?

- A. Том амсартай саванд элс овоолж орой хэсэгт нь ус асган урсгах.
B. Баримлын шаврын оройг нүхлэн, хүчиллэг бодис болон ус хийж оргилуулах.
C. Шил эсвэл хуванцар саванд савангийн хөөсийг хальж асгартал нь хийх.
D. Зэрэгцээ хоёр хавтгай саванд хар шороо овоолж хооронд нь мөргөлдүүлэх.

19. Аль мэдээ нь уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэхэд хамгийн их нөлөө үзүүлэх үйл ажиллагаа вэ?

- A. <https://gogo.mn/> сайтын мэдээ: Улиастайн гол дагуу хогийг өнгөрсөн амралтын өдөр иргэдээр цэвэрлүүлсэн ч үер усны улмаас эргээд л хог ихэссэн байна.
B. <https://1212.mn/> сайтын мэдээ: Өрхийн эрчим хүчний хэрэглээнээс ялгарсан утааны хэмжээ 2023 онд 9.1 сая тоннд хүрч, өмнөх оноос 3.2%-аар нэмэгдсэн байна.
C. <https://www.ub.life/> сайтын мэдээ: Малын тоо толгой сүүлийн 30 жилд гурав дахин нэмэгдсэний улмаас бэлчээрийн даац хэтэрч, хөрсний доройтол нүүрлэж байна.
D. <https://ikon.mn/> сайтын мэдээ: Нийслэлийн Чингэлтэй дүүрэг дэх ерөнхий боловсролын 49 дүгээр сургуулийн дээвэр дээр 72 ширхэг нарны хавтан суурилуулжээ.

20. Газарзүйн зургийн масштаб болон таних тэмдгийг ашиглан цэгүүдийн оронд тохирох үгсийг зөв дарааллаар тодорхойлсныг сонгоорой.



Нэгэн хүү амралтын өдрүүдэд жимсний талбайдаа очиж аав, ээждээ тусалдаг юм. Тэд жимсний талбайгаасаа хойш ... (1) метр явахад ... (2) усаа зөөж усалгаагаа хийдэг байна. Хүү амралтын өдөр дуусмагц жимсний талбайгаас ... (3) зүг рүү ... (4) замаар ... (5) метр алхаж харьдаг гэнэ.

- A. (1) – 300 метр, (2) – голоос, (3) – баруун, (4) – хатуу хучилттай, (5) – 700 метр
B. (1) – 30 метр, (2) – нуураас, (3) – зүүн, (4) – ердийн хөрсөн, (5) – 70 метр
C. (1) – 300 метр, (2) – голоос, (3) – зүүн, (4) – сайжруулсан хөрсөн, (5) – 700 метр
D. (1) – 30 метр, (2) – голоос, (3) – баруун, (4) – сайжруулсан хөрсөн, (5) – 70 метр